



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 01 сарын 09 өдөр

Дугаар 14

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгах,
үнийг шинэчлэн тогтоох, балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1, 7.1, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Цагдаагийн ерөнхий газрын харьяа Автобаазын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 2 нэрийн, нийт 100,500,000.00 (нэг зуун сая таван зуун мянга) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, үнийг 53,500,000.00 (тавин гурван сая таван зуун мянга) төгрөгөөр шинэчлэн тогтоож, хавсралтад заасны дагуу Дотоодын цэргийн штабт балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагч, бригадын генерал Т.Сүхболд болон тогтоолд заасан байгууллагын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоох болон балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Автомашиныг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т уурэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ
132000070
1-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2025 оны 01. дугаар сарын 03ны өдрийн
 дугаар тогтоолын хавсралт
**ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬЯА АВТОБААЗЫН ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ДАНСАНД БУРТГЭЛТЭЙ, АШИГЛАХ ХУДАЦААГ
СҮНГАХ, ҮНИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООЖ, БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖКҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГ СААЛТ**

**ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬЯА АВТОБААЗЫН ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ДАНСАНД БУРТГЭЛТЭЙ, АШИГЛАХ ХУДАЦААГ
СҮНГАХ, ҮНИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООЖ, БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖКҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГ СААЛТ**

Д/д	Автомашины нэр, марк, арлын дугаар	Үйлдвэрлэсэн, ашиглалтанд орсон он	Балансын үнэ, хурийтлагдсан элэгдэл (төгрөг)	Цаашид ашиглах хугацаа (жилээр)	Шинэчлэн тогтоох нэг бурийн үнэ (төгрөг)	Шинэчлэн тогтоох балансын нийт үнэ (төгрөг)	Хүлээн авах хуулийн этгээд нэр
1	Тоёота ландкруйзер-78, 68-94 УББ (арал-iteeb711407042738)	2018	90,000,000.00	2	45,000,000.00	45,000,000.00	Дотоодын цэргийн штаб
2	Тоёота ландкруйзер-76, 30-61 УНҮ (арал-iteib71j600044212)	2008	10,500,000.00	2	8,500,000	8,500,000.00	
	Нийт дүн		100,500,000.00 (нэг зуун сая таван зуун мянга)			53,500,000.00 (тавин турван сая таван зуун мянга)	